




Төсвийн ажлын үр дүнд, өмнөх жилд хамгийн өндөр түвшинд

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН НЭГДСЭН ДҮН /Хураангуй/



УЛААНБААТАР ХОТ
2020 ОН

**ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ
УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН
НЭГДСЭН ДҮН
/хураангуй/**


АГУУЛГА

1. ХҮН АМ	3
2.ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА	4
3.ХҮН АМЫН СУУРЬШИЛ.....	5
4. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН.....	6
5. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ.....	7
6. ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ.....	8
7.ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ.....	9
8.ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ.....	10
9.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ	12
10. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД	14
11. СУУЦНЫ НӨХЦӨЛ.....	16

1. ХҮН АМ

Монгол Улсын хүн ам 3 296 866, өрхийн тоо 897 427 болсныг тоолж гаргалаа. Хүн амын тоо 2010-2020 оны хооронд жилд дунджаар 2.2 хувиар өссөн байна. Жилийн дундаж өсөлт өмнөх тооллогоос 0.7 пунктээр нэмэгдсэн нь хүн амын цэвэр өсөлт сүүлчийн арван жилд их байсантай холбоотой юм.

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР



Тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлтийн дүр төрх өмнөх 10 жилээс бүх аймаг, нийслэлийн хувьд өссөн байна.

ЗУРАГ 2. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, 2020 ОН



Монгол Улсын хүн ам нь насны бүтцийн хувьд ерөнхийдөө залуу хэвээр байгаа ба 0-14 насны хүүхэд 31.5 хувь, 15-64 насны хүн ам 64.4 хувь, 65, түүнээс дээш насны хүн ам 4.1 хувь эзэлж байна.

Хүйсийн харьцаа өмнөх тооллогын үетэй харьцуулахад 96.6 болж 1.5 пунктээр буурчээ. Мөн хүйсийн харьцаа нь 30, түүнээс дээш насны бүлэгт буурч байгаа нь эрэгтэйчүүдийн дунд нас баралт харьцангуй илүү байдагтай холбоотой.

Хүн амыг насны бүтцийн хувьд таллан хувааж байгаа голч нас 27.9 болсон нь хүн амын тэн хагас нь 27.9-өөс доош, үлдсэн 50 хувь нь түүнээс дээш насныхан байна. Нийт хүн амын 3.7 хувь нь буюу 122.3 мянган хүн гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байна.

Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгч хүн амын тоо 55.3 байна. Хүн ам зүйн ачаалал 2020 онд 2010 оноос 10.3 пунктээр өссөн.

Хүн ам зүйн цонх үеийг ашиглан урт хугацааны бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, ялангуяа ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарснаар улс орны нийгэм, эдийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлөх юм.

2. ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА

Монгол Улсын харьяат иргэдийн үндэс, угсааны талаарх мэдээллийг өмнөх тооллогод 29 бүлгээр цуглуулж байсныг Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор 31 болгож өргөжүүлсэн. Тооллогын үр дүнгийн танилцуулгад бүлэгт 100-аас цөөн хүн амтай бүлгийг "Бусад" гэж нэгтгэсэн болно.

ХҮСНЭГТ 1. МОНГОЛ УЛСЫН ХАРЬАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Үндэс, угсаа	2010*		2020*	
	Хүний тоо	Дунд эзлэх хувь	Хүний тоо	Дунд эзлэх хувь
БҮГД	2 631 117	100.0	3 174 565	100.0
Халх	2 168 141	82.4	2 659 965	83.8
Казах	101 526	3.9	120 999	3.8
Дөрвөд	72 403	2.8	83 719	2.6
Баяд	56 573	2.2	63 775	2.0
Буряад	45087	1.7	43 661	1.4
Захайн	32 845	1.2	37 407	1.2
Дарьганга	27 412	1.0	36 419	1.1
Урианхай	26 654	1.0	29 021	0.9
Дархад	21 558	0.8	24 549	0.8
Өвөд	15 520	0.6	14 666	0.5
Хотгойд	15 460	0.6	8 583	0.3
Торгууд	14 176	0.5	15 596	0.5
Хотон	11 304	0.4	12 057	0.4
Мянгад	6 592	0.3	8 125	0.3
Тува	5 169	0.2	2 354	0.1
Барга	2 989	0.1	2 832	0.1
Үзэмжин	2 577	0.1	2 308	0.1
Элжигэн	1 340	0.1	1 034	0.0
Сартуул	1 286	0.0	2 023	0.1
Хамниган	537	0.0	384	0.0
Цаатан(Духа)	282	0.0	208	0.0
Узбек (Чантуу)	260	0.0	202	0.0
Харчин	152	0.0	154	0.0
Цахар	132	0.0	-	0.0
Хошууд	-	-	382	0.0
Бусад	601	0.0	143	0.0
Бусад үндэс, угсаатан	541	0.0	3 979	0.1


Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор Монгол Улсын харьяат суурин хүн амын 83.8 хувийг халхууд эзэлж, өмнөх тооллогоос 1.4 пунктээр өссөн байна. Казахуудын нийт хүн амд эзлэх хувийн жин 3.8 хувь байгаа нь халхуудын дараа орж байна. Харин Дөрвөд, Баяд, Буриад угсаатнууд 2010 оноос буурсан байна.

3.ШАШИН

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 59.4 хувь нь шашин шүтдэг, 40.6 хувь нь шашин шүтдэггүй гэж тоологдлоо. Шашин шүтлэгтэй хүмүүсийн 87.1 хувь нь буддын шашинтан байна.

Хүн амын дийлэнх нь буддын шашинтан боловч насны бүлгээр авч үзэхэд 15-19 насны өсөөр үеийнхний хувьд христ, исламын шашинтан олонх байна. Мөн үндэс, угсаанаас хамааран шашин шүтэх, эс шүтэх нь харилцан адилгүй бөгөөд Казах угсаатнуудын 84.7 хувь нь шашин шүтдэг ба 81.9 хувь нь ислам шашинтан байна.

ЗУРАГ 3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭЙ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН




3.ХҮН АМЫН СУУРЬШИЛ

Монгол Улсын хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд нийт хүн амын 46 хувь нь Улаанбаатар хотод, 19 хувь нь хангайн бүсэд, 16 хувь нь төвийн бүсэд, 13 хувь нь баруун бүсэд, 7 хувь нь зүүн бүсэд оршин сууж байна.

Төв суурин газар уруу 1990-ээд оны эхэн үеэс эхэлсэн шилжилт сүүлийн 20 гаруй жилд үргэлжилсэн хэвээр байна. Ерөнхийдөө хүн амын шилжилт хөдөлгөөн Улаанбаатар руу чиглэж байгаа нь олон баримтаас харагддаг.

ЗУРАГ 4. ХҮН АМЫН ТОО, СУМААР, 2020 ОН




Монгол Улсын хүн амын нягтрал 2000 онд нэг квадрат километр нутаг дэвсгэрт 1.5 хүн ногдож байсан бол 2010 онд 1.7 хүн, 2020 онд 2.1 болж өссөн нь үндэсний түвшинд хүн амын ердийн цэвэр өсөлтийн нөлөө юм.

Аймаг, нийслэлийн хүн амын нягтралын өөрчлөлтөд дээр дурдсан хүчин зүйлсээс гадна дотоод шилжих хөдөлгөөн ихээхэн нөлөөлсөн байна. Улаанбаатар хотын хүн амын нягтрал 2010 оноос 2020 оны хооронд 33.4 хувь, Орхон аймгийнх 28.0, Дархан-Уул аймгийнх 17.8 хувиар тус тус өссөн нь шилжих хөдөлгөөнтэй холбоотой.

4. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Төрснөөс хойших аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогч нийт суурин хүн амын 23.4 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 9.7 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 5. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР, 2020 ОН



Сүүлийн 5 жилийн шилжих хөдөлгөөн аймаг, нийслэлийн хооронд (49.1 хувиар) болон бүсүүдийн хооронд (49.0 хувиар) мөн адил буурсан үзүүлэлттэй байна.

Бүсүүдийн хоорондын сүүлийн 1 жилийн шилжих хөдөлгөөнд оролцогч 80.5 мянга байгаа нь 2010 оныхоос 20.4 хувиар буурчээ.

Энэ нь сүүлийн жилүүдэд Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал эрчимжсэнтэй холбоотой.

Улаанбаатар хотын хүн амын тоо өсөж, төлөвлөлтгүй суурьшил бий болсон нь юуны түрүүнд хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Төрөөс үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн зэрэг үйлчилгээ хэт ачааллаас болж доголдох, ялангуяа гэмт хэрэг, зөрчил нэмэгдэж, замын хөдөлгөөнд түгжрэл үүсэх зэргээр нийгмийн харилцаа, эдийн засаг үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арав зургаадугаар зүйлийн 2-т заасан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг энэ шилжилт хөдөлгөөнөөс улбаатай сөрөг үр дагаврууд ноцтой хөндөж байгаа тул Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2017 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн захирамжаар хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл зогсоосон шийдвэртэй холбоотой юм.

5. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Арав, түүнээс дээш насны хүн амын 95.1 хувь нь ямар нэгэн боловсролын түвшин эзэмшсэн байна. Харин 15, түүнээс дээш насны хүн амын 96.7 хувь нь бичиг үсэг тайлагдсан байна.

Боловсролын түвшин өмнө жилүүдээс харьцангуй өссөн ба бичиг үсэг мэддэггүй хүн амын түвшин буурчээ. Арав ба түүнээс дээш насны хүн амын дунд бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь багассан байна. Харин дийлэнх нь буюу 29.2 хувь нь бүрэн дунд боловсролтой байна.

ЗУРАГ 6. 10, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ТОО, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, 2020 ОН



* Нийт 10 ба түүнээс дээш насны хүн амын тоонд Монгол Улсад удаан хугацаагаар амьдарч байгаа гэдгээд улсын иргэдийг хамруулсангүй болно.

Дээд боловсролтой хүн амын түвшин урьд оноос өссөн үзүүлэлттэй гарч байна. Арав ба түүнээс дээш насны Монголын харьяат суурин хүн амын 26.5 хувь нь дээд ба түүнээс дээш боловсролтой болсон нь 2010 оны үр дүнтэй харьцуулахад 8.2 пунктээр өссөн байна.

6. ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор нийт өрхийн тоо 2010 оноос 25.7 хувиар өссөний дотор хотын өрх 26.4 хувиар, хөдөөгийн өрх 24.3 хувиар тус тус өссөн байна.

Улсын хэмжээнд 897.4 мянган өрх тоологдсоноос 59.7 хувь нь ам бүлээрээ байгаа өрх, 22.7 хувь нь нийлмэл ам бүлтэй, 15.4 хувь нь ганц бие, 2.2 хувь нь холимог ам бүлтэй өрх байна.

Нийлмэл ам бүлтэй өрхийн тоо хотод хөдөөгөөс 3.9 дахин олон байна. Энэ нь төв суурин газарт орон сууцны хүрэлцээ хангамж тааруу, түрээсийн байрны хөлс өндөр, хөдөөгөөс шилжин ирэгчид хамаатан садантайгаа хамт амьдрах нь ихсэж байгаатай холбоотой юм. Ганц бие өрхийн тоо хотод өмнөх тооллогын үеийнхээс 1.8 дахин өссөнийг мөн шилжих хөдөлгөөнтэй холбон тайлбарлах болох юм.

ЗУРАГ 7. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН



Улсын хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо 3.6 болсон нь 2010 оны улсын дундаж тоотой ижил байна. Харин 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь ихээхэн өөрчлөгджээ. Тухайлбал, 1-2 ам бүлтэй өрх хотод 4.5 пунктээр, хөдөөд 5.1 пунктээр өмнөх тооллогын дүнгээс нэмэгдсэн байна. Үүнийг шилжих хөдөлгөөн өөрөөр хэлбэл, хотод их, дээд сургуульд суралцагчид, болон ажил хөдөлмөр хийхээр шилжин ирсэн хүмүүс тусдаа өрх болж тоологдсонтой холбоотой байж болох юм.

Хүн амын гэрлэлтийн байдалд огт гэрлээгүй хүмүүс өмнөх тооллогоос 0.2 пункт, гэр бүлтэй хүмүүс 0.5 пунктээр, харин цуцалсан хүмүүс 0.7 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 8. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС, 2000, 2010, 2020 ОН



Анхны гэрлэлтийн дундаж нас 27.7 болсон бөгөөд 2010 онтой харьцуулахад хоёр насаар хойшилсон байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн насны ялгаа ойролцоогоор нэгээс хоёр насны зөрүүтэй байгаа нь сүүлийн 20 жилд өөрчлөгдсөнгүй.


7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

Улсын хэмжээнд 106.4 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт суурин хүн амын 3.3 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 58.9 мянга буюу 55.4 хувь нь эрэгтэй, 47.4 мянга буюу 44.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН



ЗУРАГ 10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд өмнөх тооллогоос 13.9 мянга буюу 37.7 хувиар өссөн нь сүүлийн 10 жилд агаарын бохирдол болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр эхээс төрөхдөө л хөгжлийн бэрхшээлтэй байна гэсэн үг юм.

Харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өмнөх тооллогоос 15.6 мянга буюу 21.8 хувиар буурсан нь аж ахуй нэгжийн аюулгүй ажиллагаа болон үйлдвэрийн осол гэмтэл, хүнд нөхцөлийн аюулгүй ажиллагаа сайжирсан байж болох юм.

Иймд төрөлхийн бэрхшээл их байгаа шалтгааныг удамшлын эмгэг, эх барихын болон төрөх үеийн хүндрэл, хорт нөлөө, агаарын бохирдол зэрэг олон талаас нь нарийвчлан судлах шаардлага байна гэж харж байна.

Хөгжлийн бэрхшээлийг хэлбэрээр нь авч үзвэл хөдөлгөөний бэрхшээл 2010 оны тооллогоос 23.3 хувь, харааны бэрхшээл 23.3 хувь, сонсголын бэрхшээл 31.2 хувиар тус тус буурч, сэтгэцийн бэрхшээл 3.0 хувиар өссөн байна.

Нийт бэрхшээлийн дийлэнх буюу 33.9 хувийг бусад (Хавсарсан болон бусад хөгжлийн бэрхшээлийг энд оруулав), 22.5 хувийг хөдөлгөөний бэрхшээл эзэлж байгаа бол хамгийн бага буюу 3.1 хувийг харааны бэрхшээл эзэлж байна.

ҮЙЛДЛИЙН ЧАДВАР

Насны бүлгээр авч үзэхэд 20-24 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн хамгийн их хүндрэл нь ой тогтоол/ санах байгаа бол 35-54 насныхны хувьд алхах, харин 55 түүнээс насныхны хувьд алхах, өөртөө анхаарал тавих хүндрэлүүд байгаа нь нас ахих тусам дгээр хүндрэл зонхилж байгааг харж болохоор байна.

ЗУРАГ 11. ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



8.ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ


Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор зургаа ба түүнээс дээш насны нийт суурин хүн амын 67.8 хувь нь гар утас хэрэглэж байгаа бол 64.7 хувь нь интернэт хэрэглэгчид байна. Зургаа ба түүнээс дээш насны гар утас, интернэт хэрэглэгчдийн дүнд эзлэх хувь 2010 оноос харьцангуй өссөн ба гар утас хэрэглэгчид 17.8%-аар интернэт хэрэглэгчид 34.1%-аар тус тус өссөн байна.

ЗУРАГ 12. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ГАР УТАС ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН



Дэлхий нийтээр даяаршиж интернэтийн хэрэглээ маш хурдан өссөөр байгаа ба Монгол Улсад ч бас 3G болон 4G сүлжээ орж ирснээр гар утас болон байнга интернэт хэрэглэгчдийн тоо ихэссэн байна.

ЗУРАГ 13. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



9. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Хөдөлмөрийн насны буюу арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 59.7 хувь нь ажиллах хүчинд багтаж байгаа нь 2010 оноос 3.3 пунктээр өссөн бол ажиллах хүчнээс гадуурх хүн ам (40.3%) 3.3 пунктээр буурчээ. Ерөнхийд нь үзвэл ажиллах хүчний оролцооны түвшин өнгөрсөн тооллогын үеийнхээс өссөн, ялангуяа эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо өмнөх тооллогын үеийнхээс 4.5 пунктээр өссөн байна.

Нийт хөдөлмөрийн насны хүн амд ажил эрхэлдэг хүн амын залэх хуаь өнгөрсөн тооллогын үеийнхээс 6.0 пунктээр нэмэгдэж, ажиллах хүчнээс гадуурх хүн амын хувийн жин 3.3 пунктээр буурч, ажилгүй иргэд 5.9 хувийг эзэлж байна. 55 наснаас эхлэн цаашид нас ахих тутам хүмүүсийн хөдөлмөрийн чадвар буурч, 60, түүнээс дээш насны хүн амын 16.7 хувь ажиллах хүчинд хамрагдаж байгаа ч өмнөх тооллогын үеийнхээс тухайн насны хүн амын ажиллах хүчинд залх хувь 8.3 пунктээр нэмэгдсэн нь эерэг үзүүлэлт байна.


ЗУРАГ 14. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮБЧ, 2020 ОН



Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо, эмэгтэйчүүдийнхээс өндөр хэвээр байна. Байршлын хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь ажиллах хүчний оролцоо хөдөөд хотынхоос өндөр байна. Ялангуяа, хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 69.1 хувь байгаа нь хотынхоос 5.8 пунктээр илүү байна.


Арван тав, түүнээс дээш настай нийт хүн амын 53.8 хувь нь ажил эрхэлж байхад энэ үзүүлэлт хөдөөд 60.6 хувь байгаа нь хөдөөгийн хүн амын дийлэнх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэгтэй холбоотой. Ялангуяа, хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт хотынхоос 11.8 пунктээр өндөр байгаа нь хөдөөгийн эрэгтэйчүүдийн дийлэнх нь мал аж ахуй эрхэлж байгаагаар тайлбарлагдана.

ЗУРАГ 15. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, АЙМГААР, 2020 ОН



Улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2020 онд 9.9 хувь болж, өмнөх тооллогын үеийнхээс 5.4 пунктээр буурчээ. Ажилгүйдлийн түвшин хотод өндөр, хөдөөд бага байна. Энэ нь нэг талаас хот суурин бараадсан шилжих хөдөлгөөн их байгаа, нөгөө талаас тэд хотод шилжин ирээд ажлын байр олох боломж муу байдагтай холбоотой.

ЗУРАГ 16. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХУВИАР, АЙМГААР, 2020 ОН



Ажилгүй иргэдийн дотор 30-44 насны 63.0 мянган хүн байгаа нь хамгийн их буюу нийт ажилгүй хүний 49.1 хувийг эзэлж байна. Харин 30-аас дээш насныханд эрэгтэйчүүд илүү их ажилгүйдэлд өртөж байна.

Улсын хэмжээнд ажиллах хүчнээс гадуурх хүн ам нийтдээ 873.8 мянга байгаа нь өмнөх тооллогоос 5.2 хувиар, үүний дотор ажиллах сонирхолгүй хүний тоо 11.3 хувиар, сургуульд

сурдаг 8.9 хувиар тус тус өсжээ. Харин хөдөлмөр эрхлэх чадваргүй, гэрийн ажилтай, тохирох ажил оддохгүй байгаа хүмүүсийн хувь 14.7-18.3 хувиар буурсан байна.

15-24 насны хүн амын 12.2 хувь нь хөдөлмөр эрхлээгүй, сургуульд сураагүй залуучууд байна. Ялангуяа 15-24 насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлээгүй, сургуульд сураагүй хувь улсын дүнгээс 0.3 пунктээр илүү байна. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны хүн ам их байгаа хүн ам зүйн таатай нөхцөл байдал, боломжийг ашиглаж чадахгүй байгааг цаашид анхааран судлах шаардлагатай юм.

10. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа 122301 иргэн тоологдож 2010 оноос 14.2 хувиар өсжээ.

ЗУРАГ 17. ГАДААДАД ОРШИН СУУГАА
МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, УЛСААР, 2020 ОН



Гадаадад тоологдсон иргэдийн 2 хүний 1 нь буюу 58.8 хувь нь Ази, Номхон далайн бүс нутагт, 5 хүн тутмын 1 нь Европ тивд суугаагаар тоологдсон байна.

Монгол Улсын баруун бүсээс явсан хүн амын 10 хүн тутмын 9 нь Ази, Номхон далайн бүс нутагт суугаагаар тоологдсон байна.

Гадаадад тоологдсон хүн амын дүнг оршин сууж байсан аймгаар нь 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад Говьсүмбэр аймгаас явсан хүний тоо 3.2 дахин, Ховд аймгийнх 2.9 дахин, Баян-Өлгий, Дорноговь аймгаас явсан хүний тоо ойролцоогоор 2 дахин өссөн байна. Харин Завхан, Говь-Алтай аймгаас гадаад улсад байнга оршин сууж байгаа хүн амын тоо өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад буурсан байна.

ЗУРАГ 18. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН



Тооллогын үед суурьших зорилгоор гадаадад оршин суугаа хүмүүсийн 25.1 хувь нь анх суралцахаар явсан байна. Харин тооллогын үед хувиараа ажиллахаар оршин суугаа хүний 19.8 хувь нь анх суралцахаар явж байжээ.

Анх суралцах зорилгоор явсан гадаадад оршин суугаа хүмүүсийн 7.9 хувь нь тооллогын үед хувиараа ажиллах зорилгоор тухайн улсдаа суурьшиж байна. Мөн анх бусад зорилгоор гадаадад оршин сууж байсан хүмүүсийн 13.1 хувь нь тооллогын үед суурьших зорилгоор гадаадад оршин сууж байна.

ЗУРАГ 19. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДГНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



11. СУУЦНЫ НӨХЦӨЛ

Монгол Улсад Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр нийт 897.4 мянган өрх 770.9 мянган сууцанд амьдарч байна. Амьдарч буй өрхийн тоо, хүн байнга амьдардаг сууцны тооны харьцаа хотод ойролцоо байхад, хөдөөд өрхийн тоо нь илүү байна. Энэ нь хөдөөд нэг сууцанд олон өрхүүд хамт амьдарч байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 2. ГЭР, БАЙШИН, ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, /мянга/ 2019, 2020 ОН

	Хүн байнга амьдардаг сууц			Өрхийн тоо		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	770.9	557.2	213.7	897.4	606.3	291.1
Гэр	225.9	98.3	127.6	342.4	149.9	192.5
Байшин	545.0	458.9	86.1	547.0	451.6	95.3
Бусад сууц	-	-	-	8.0	4.8	3.3

Тайлбар: *Орон сууцны байшингийн доторх сууцыг нэмж оруулав

Нийт өрхийн 38.2 хувь нь монголын ард түмний уламжлалт сууц болох гэрт, 60.9 хувь нь байшинд, 0.9 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 7.1 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 7.3 пунктээр нэмэгджээ.

ЗУРАГ 20. ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, 2020 ОН



Байшин, орон сууцны тооллогоор хүн байнга амьдардаг 442.7 мянган сууц, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулбал 770.9 мянган сууц тоологдсон. Харин хүн байнга амьдардаггүй илүү гэр, зуслангийн байшин зэрэг 234.9 мянган сууц тоологджээ.

ЗУРАГ 21. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН



Тооллогоор хүн байнга амьдардаг сууцнаас сууцны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг амьдарч буй өрхөөс асууж цуглуулсан.

Хүн байнга амьдардаг сууцыг төрлөөр авч үзвэл 51.0 хувь нь гэр сууц, 46.0 хувь нь сууцны тусдаа байшин, 1.7 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны байшин, 0.9 хувь нь бие даасан тохилог сууц, 0.4 хувь нь нийтийн байр тоологдсон байна.

Нийтийн зориулалттай 7444 орон сууцны байшинд 335587 сууц тоологдсон байна.